

ОХУ болон БНАСАУ-ын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв

Г.Базарваань¹, Т.Төрболд²

¹АББСТ-ийн ахлах шинжээч, доктор (Ph.D.)

²Докторант

ABSTRACT

The relationship between Russia and North Korea has been shaped by historical, geopolitical, and economic factors, undergoing significant evolution in recent years. This article examines the current dynamics of their bilateral ties, highlighting shared strategic interests, mutual opposition to Western dominance, and Russia's role as a counterbalance to North Korea's dependence on China. Key areas of cooperation include military technology, trade, and political solidarity against sanctions. However, the relationship faces challenges due to Russia's broader international commitments and North Korea's isolationist policies. The article also explores potential future trajectories, emphasizing the impact of regional security concerns, sanctions regimes, and shifts in global power dynamics. Greater cooperation could emerge, driven by mutual needs in a changing geopolitical environment, yet limitations persist due to economic constraints and international scrutiny.

Keywords: *geopolitic, economic, strategic interest, trajectory.*

ОРШИЛ

Олон улсын харилцаа, геополитикийн өөрчлөлт бүс нутгийн уур амьсгалыг тогтворгүй болгож, архагшсан аюулгүй байдлын эрсдэлт халуун цэгүүдийг хөдөлгөөнд оруулахын зэрэгцээ холбоотны харилцааг бэхжүүлэх их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөнийг эрчимжүүлж байна.

Тухайлбал, Зүүн Хойд Ази (цаашид ЗХА гэх)-ийн аюулгүй байдлын динамикийг өөрчилж болзошгүй үйл явцад 2023 оны наймдугаар сарын 18-ний өдөр болсон Кемп Дэвидийн дээд хэмжээний уулзалтын дараах “Япон-Солонгос-Америкийн гурван талт холбоотны харилцаа”, “Орос-Умард Солонгосын тал батлан хамгаалах харилцан туслалцах гэрээ”-г сэргээсэн зэрэг үйл явдлыг нэрлэж болно.

Орос болон Умард Солонгосын харилцааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хоёр улсын цаашдын харилцаа хамтын ажиллагааг бүс нутгийн аюулгүй байдлын орчин, дэлхийн геополитикийн нөхцөл байдалд уялдуулж таамаглах, болзошгүй хувилбар, анхаарах асуудлыг тодорхойлохыг энэхүү өгүүлэлд зорьсон болно.

Нэг. Пёньян, Москвагийн өнөөгийн харилцаа

Москва, Пёньяны өнөөгийн харилцааны онцлогийг тодруулах, дүн шинжилгээ хийхийн тулд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины засаглалын үед болсон хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлалын давтамжийг авч үзье.

Хүснэгт 1. ОХУ-БНАСАУ-ын өндөр дээд түвшний харилцан айлчлал

ОХУ-ын талаас			
№	Түвшин	Он, сар	Үр дүн
1	Ерөнхийлөгч В.Путин	2007.07	Ким Дэ Жун, Ким Чен Ир нарын дээд хэмжээний уулзалтын дараа Умард Солонгост гадаад орчны тусгаарлалтыг даван туулах дипломат дэмжлэг болсон. Өрнөдийн хамтын нийгэмлэг “тээгдсэн” хэмээн зарласан улсад Оросын Ерөнхийлөгч айлчилсан явдал Пёньяны дэглэмийг хамтаар буруутгахад Москва нэгдэхээс татгалзаж буй илрэл болсон.
		2024.06	Батлан хамгаалах харилцан туслах гэрээ байгуулсан. Үүгээр ЗХУ-БНАСАУ-ын хооронд 1961 онд байгуулсан цэргийн холбоотны харилцааг сэргээсэн.
2	Гадаад хэргийн сайд С.Лавров	2023.09	Пёньянд хийсэн айлчлалын үеэр хоёр орны харилцаа “стратегийн шинэ түвшинд хүрсэн” хэмээн мэдэгдсэн.
3	Батлан хамгаалахын сайд С.Шойгу	2023.07	Умардын баллистик пуужингийн үйлдвэрлэлтэй танилцаж, “Батлан хамгаалах экспо”-д зочилсон.
БНАСАУ-ын талаас			
1	Их удирдагч Ким Жон Ил	2001.07-08	Москвагийн тунхаглалд гарын үсэг зурж, хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх хүсэлтэйгээ нотолсон ч тодорхой үр дүнд хүрээгүй.
		2002.08	Владивостокт В.Путинтэй уулзаж, Транс-Солонгос болон Транссибирийн төмөр замыг холбох асуудлын талаар хэлэлцсэн.
		2011.08	Приморьес Өмнөд Солонгос руу төмөр замаар холбох, байгалийн хийн хоолой барих асуудлын талаар санал солилцсон. Ким Чен Ир Хойд Солонгосын 11 тэрбум ам.долларын өрийн 90 хувийг Москва тэглэх тохиролцоонд хүрсэн. Энэхүү гэрээг 2014 онд төрийн ДУМ соёрхон баталж, үлдэгдэл 10 хувийн өрийг 20 жилийн дотор БНАСАУ төлөх болсон.

	Их удирдагч Ким Жон Ун	2019.04	Ким Чен Ун анх удаа В.Путинтай уулзсан. Удирдагчид хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээ амласан ч дорвитой үр дүнд хүрээгүй.
		2023.09	БНАСАУ-ын төлөөлөгчид 150 хүний бүрэлдэхүүнтэй, хуягт галт тэргээр Пёньянаас хөдөлж, нийт 4000 орчим км замыг туулж, Оросын Алс Дорнод дахь хэд хэдэн сансрын цогцолборт зочилсон. БНАСАУ-аас ОХУ-д зэвсэг, сум нийлүүлэх тохиролцоонд хүрсэн.
2	Гадаад хэргийн сайд	2024.01	Геологийн хамтарсан хайгуул хийх, ОХУ-д суралцах оюутан суралцагчдын квотыг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцсон. Хоёр талын өндөр дээд түвшний харилцан айлчлал нэмэгдэж, бүх талын хамтын ажиллагааг идэвхжүүлж буй “мессеж” олон улсад өгөх дипломат алхам болсон.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд хоёр улсын харилцаа эрчимжиж байна. Энэ нь дэлхийн геополитикийн тавцанд Орос-Умардын тал нийтлэг ашиг сонирхолтой байгаатай холбоотой. Хоёр талын харилцааг авч үзвэл нийтлэг эрх ашигтай үед идэвхтэй харилцдаг онцлогтой. Тухайлбал В.Путин ОХУ-ыг удирдах болсноор их гүрний статусаа сэргээх бодлого баримталж, хуучин ЗХУ-ын үеийн макро нөлөөний бүсээ хадгалах, уг бүсэд Өрнөдийн орнуудын нөлөөг нэвтрүүлэхгүй байх үүднээс Умард-Өмнөдийн дээд хэмжээний уулзалтын дараахан Пёньянд айлчилж, БНАСАУ-ын дэглэмийг хүлээн зөвшөөрч харилцааа олон улсын тавцанд мэдэгдэж байсан. Гэвч Өрнөдийн орнуудад түлш, эрчим хүчний бүтээгдэхүүнээ нийлүүлэх таатай эдийн засгийн орчин бүрдэж, улс төрийн зөвшилцөл нэмэгдмэгц Умард Солонгост тавьсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн есөн тогтоолд нэгдэж, зэвсгийн худалдаа, пуужингийн технологи дамжуулах, Пёньян руу тансаг хэрэглээний бараа тээвэрлэхийг хориглох зэрэг арга хэмжээ авсан байдаг¹.

Умардын удирдагч АНУ-ын Ерөнхийлөгчтэй уулзсаны дараа түүнийг 2019 онд ОХУ-д айлчлахыг урьж, хоёр талын хамтын ажиллагааг бүхий л талаар хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал гаргасан ч тодорхой үр дүнд хүрээгүй. Улмаар Орос-Өрнөдийн харилцаа хүйтэрч, тэдний геополитикийн өрсөлдөөн ширүүсч, Украины нутаг дэвсгэрт дайн хийж эхэлсний дараа Владивостокт Ким Чен Унтай дахин уулзаж, тус улстай харилцаагаа идэвхжүүлэх болсон. Энэ нь Пёньяны ашиг сонирхолд мөн нийцсэн. Учир нь АНУ тэргүүтэй Өрнөдийнхөн ОХУ-тай зөрчилдсөнөөр олон улсын харилцааны зөрчилдөөний хүндийн төв Европ руу хэлбийж, БНАСАУ-ын цөмийн амбицид бүрэн хяналт тавихгүй байх нөхцөлийг бүрдүүлж өгч байна. Мөн Москваг дэмжиж, зэр зэвсэг нийлүүлэх болсон нь Пёньянд ОХУ-аас байгалийн хий, нефтийн бүтээгдэхүүн авахын зэрэгцээ зэвсэглэлийн үйлдвэрт хамтран ажиллах, цөмийн дэвшилтэт технологийг

¹ Россия и урегулирование ситуации на Корейском. https://mid.ru/ru/foreign_policy/vnesnepoliticeskoe-dos-e/krizisnoe-uregulirovanie-regional-nye-konflikty/uregulirovanie-situacii-na-korejskom-poluostrove/ (retrieved: 2024.09.18)

нутагшуулах зэрэг боломжийг олгоод байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2024 оны зургаадугаар сарын 19-ний өдөр Пёньянд хийсэн төрийн айлчлал² бол нэг талаар БНАСАУ-ын удирдагч Ким Жон Уны айлчлалын хариу айлчлал мэт боловч улс төрийн агуулгаараа Москва, Пёньяны харилцааг бэхжүүлэх чухал алхам болсон юм. Энэхүү айлчлал БНАСАУ-ын талаар баримталж буй ОХУ-ын бодлогод өөрчлөлт гарч болзошгүйг харуулж байна.

Хоёр. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны хэтийн төлөв, таамаглал

Хоёр улсын харилцаа идэвхжихэд бүс нутгийн болон олон улсын геополитикийн нөхцөл байдал, тэдний нэгдмэл ашиг сонирхол ямагт нөлөөлж ирсэн. Эдүгээ Өрнөдийг сөрөх хоёр улсын ашиг сонирхол давцаж, харилцан айлчлалын давтамж нэмэгдэж, талууд “шинэ стратегийн түншлэл”-ийн харилцаанд шилжээд буй. Үүнээс хоёр улсын харилцаа дараах хоёр хувилбараар өрнөж болзошгүй байна.

Хувилбар 1. Хоёр улсын холбоотны харилцаа бүхий л талаар өргөжинө

АНУ болон түүний ЗХА дахь холбоотны эсрэг дэглэмээ хадгалах, хүлээн зөвшөөрүүлэхийн тулд цөмийн зэвсгийг хөгжүүлэх, албан ёсоор (de-jure) цөмийн зэвсэгтэй улс статустай болох, цөмийн технологийг нутагшуулах Пёньяны сонирхол Өрнөдийг сөрж буй Москвагийн стратегийн өрсөлдөөнийг дэмжих үндсэн шалтгаан болно. БНХАУ-аас улам бүр эдийн засгийн хамааралтай болж буй Умард Солонгосын тухайд Ким Ир Сэний үед баримталж байсан Орос-Хятадтай “ижил зай”-тай харилцах бодлогыг явуулах шаардлага үүсээд буй. Иймээс Оростой холбоотны харилцаагаа сэргээсэн явдал нэн тэргүүнд Бээжинтэй батлах хамгаалах холбоотонтойгоо харуулах, Өрнөдийхөнд Москваг дэмжих хүч бийг анхааруулах алхам болсон гэж үзнэ. Үүгээр үзэл сурталд суурилсан хоёр улсын хамтын ажиллагаа үзэл баримтлал, нэгдмэл алсын хараа болж өргөжиж болзошгүй. Энэ тохиолдолд улс төрийн харилцаанаас батлан хамгаалах, эдийн засгийн хамтын ажиллагаанд шилжих боломжтой.

Хоёр улсын хамтын ажиллагааны үндсэн салбар зэвсэг техникийн үйлдвэрлэл байж болзошгүй. Учир нь Орос Умардтай бүрэн хэмжээний хамтын ажиллагаа, тэр дундаа цэрэг-техникийн салбарт хамтран ажиллахын тулд хориг арга хэмжээний дэглэмийг дагаж мөрдөхөөс илт татгалзаж байна. Москва Пёньянд цэргийн техник гэхээсээ илүү хэрэгтэй технологийн элементүүдийг шилжүүлэх, онцгой тохиолдолд Умард Солонгосын технологийг Орос руу шууд зэвсэг, зэвсгийн нийлүүлэлт биш, харин тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгч болгох хувилбар байж болно.

Ким Жон Ун 150 хүний бүрэлдэхүүнтэй, хуягт галт тэргээр 2023 оны есдүгээр сарын 10-ны өдөр Пёньянаас хөдөлж, нийт 4000 орчим км замыг туулахдаа Оросын Алс Дорнод дахь хэд хэдэн томоохон сансрын цогцолбор, тухайлбал Восточный сансрын буудал, Комсомольск-на-Амур дахь Гагарины нэрэмжит сөнөөгч онгоцны үйлдвэр зэрэг Оросын дэвшилтэт техник, технологитой танилцаж зочилсон явдал

² Российско-корейские переговоры. <http://kremlin.ru/events/president/news/74330> (retrieved: 2024.09.18)

нь олон улсад Орос болон Умард Солонгосын харилцаа батлан хамгаалах салбарт өргөжиж байгаагаа нотлон харуулсан³. Умард Солонгосын удирдагч энэхүү айлчлалынхаа үеэр Оросын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзаж, зэвсэг, сум галт хэрэгсэл нийлүүлэх, солилцох болон цөмийн технологийг нутагшуулах асуудлаар хэлэлцсэн байх магадлалтай. ЗХУ-ын үеийн тоног төхөөрөмжийн томоохон нөөцтэй Умард Солонгосоос Орос зэр зэвсгийн тусламж хүсэж, Пёньян илгээхээр Кимийн айлчлалын өмнө тохиролцсон байх магадлал өндөр байна. Учир нь В.Путин, Ким Жон Ун нарын дээд хэмжээний уулзалтаас сарын дараа Умард Солонгосоос Орос руу 1000 орчим чингэлэг тоног төхөөрөмж, сум хэрэгсэл илгээсэн, Орос эдгээр чингэлэгийн заримыг өнгөрсөн оны 10 дугаар сарын дундуур Украины хилээс 200 км-ийн зайд байрлах зэвсгийн агуулахдаа хүргэсэн байж болзошгүй хэмээн АНУ мэдэгдсэн⁴. Хиймэл дагуулаас авсан зургаас харахад өнгөрсөн наймдугаар сарын сүүлчээс эхлэн ийм төрлийн таван удаагийн тээвэрлэлт хийсэн байж болзошгүй байгаа явдал үүнийг нотолж буй.

Хоёр улсын хамтын ажиллагааны өөр нэг салбар бол эдийн засгийн хамтын ажиллагаа байх боломжтой. Аль аль нь эдийн засгийн хоригт өртсөн хоёр улс энэ салбарт хамтран ажиллах явдал хэн хэнийнх нь ашиг сонирхолд нийцнэ. Ялангуяа Өрнөдийн хоригт өртсөн Оросын эдийн засагт Ази, Номхон далайн бүс нутгийн улс оронтой харилцаагаа бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай бол Хятадаас эдийн засгийн ихээхэн хамааралтай болсон Умард Солонгосын тухайд энэ салбарт хамтран ажиллах боломжтой цөөн улсын нэг Орос болно.

НҮБ-аас БНАСАУ-д тавьсан хориг арга хэмжээг илэрхий зөрчихгүй шууд бус аргаар эдийн засгийн хамтын ажиллагаа, тээвэр, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, тус улсад үзүүлэх Оросын технологийн тусламж, соёл, хүмүүнлэгийн солилцоо, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг хамтын ажиллагааны одоо байгаа салбаруудыг цаашид хөгжүүлэх асуудал анхаарах гол чиглэл байх болов уу. Хэдийгээр Москва, Пёньяны эсрэг тавьсан хориг арга хэмжээг зөрчиж байгаа ч НҮБ-ын тогтоолыг шууд үл тоомсорлох бус нууц хамтын ажиллагаа эхлүүлж болзошгүй. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хамтын ажиллагааны арга замыг эрэлхийлэхдээ хориг арга хэмжээг илэрхий зөрчихгүй байх, эсвэл цоорхойг ашиглах гарцыг хайна гэсэн үг. Ийм ажлыг Засгийн газар хоорондын комиссоор дамжуулан хийх магадлалтай.

Хориг арга хэмжээнд өртөөгүй аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах хэтийн төлөв бий. Оросын эхний бүлэг жуулчид Умард Солонгост хэдийнээ очиж эхэлсэн⁵. Үүгээр Пёньян руу идэвхтэй аялж, хятадын жуулчдаас давах магадлалтай. Вонсан дахь аялал жуулчлалын кластер, Кумганг ууланд барьсан цогцолбор

³ Ким Чен Ён прибыл в Россию на роскошном бронепоезде. Что о нем известно. В составе есть поющие проводницы и большой выбор изысканных блюд. <https://www.rbc.ru/life/news/65005aa99a7947bfa39eab5> (retrieved: 2024.09.18)

⁴ US says North Korea delivered 1,000 containers of equipment and munitions to Russia for Ukraine war <https://apnews.com/article/north-korea-russia-us-munitions-ukraine-war-7091eaba254b680888a9b1ec8a68135f> (retrieved: 2024.09.18)

⁵ Russians arrive in North Korea as first foreign tour group since COVID-19. <https://www.aljazeera.com/news/2024/2/9/russians-arrive-in-north-korea-as-first-foreign-tour-group-since-covid-19> (retrieved: 2024.09.18)

үндсэндээ оросуудад зориулсан гэдэг. Үүний зэрэгцээ Умард Солонгосын ажиллах хүчийг Оросын хуулийн дагуу “нэмэлт орлого олох эрхтэй оюутан сургах” нэрийн дор оруулж ирэх магадлалтай.

ОХУ газрын тосны бүтээгдэхүүнийхээ экспортыг хязгаарлаж байгаа ч Засгийн газар хоорондын гэрээтэй болон хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд нийлүүлэхээр тохиролцсон улс оронд нийлүүлтээ хэвээр хадгалахаа мэдэгдсэн. Иймээс Умардад байгалийн хий, нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой.

Хоёр улс тээвэр, харилцаа холбооны дэд бүтцийн салбарт хамтран ажиллах боломж бий. Тухайлбал, хил дамнасан авто замын гүүр, байнгын төмөр замын үйлчилгээ бий болохоос гадна Умард Солонгост Оросын үүрэн холбооны хэрэгсэл нэвтрэх, эсвэл холбогдож болзошгүй. Умард Солонгосын тодорхой хэсгийг Оросын интернетэд холбож болно. Үүний зэрэгцээ хакерын бүлгүүдийн хамтын ажиллагаа, эсвэл Умард Солонгосын мэргэжилтнүүдийг ийм зүйлд сургах биш, харин хамтын аюул заналхийллээр улс орнуудыг нэгтгэх дараагийн түвшинд боломжтой.

Энэ бүх аргумент хоёр улсын харилцаа ойрын болон дунд хугацаанд бэхжиж болзошгүйг харуулж байна.

Хувилбар 2. Хоёр улсын холбоотны харилцаа олон улсын тавцанд “мессеж” төдий үлдэнэ

Хоёр улсын харилцааны хэтийн төлөв сүүлийн 30 жилд тогтсон хэлбэрээсээ төдийлөн өөрчлөгдөхгүй байх хувилбар мөн бий. Хэдийгээр батлан хамгаалах салбарын харилцаа ойрын хугацаанд идэвхтэй байх боловч дунд болон удаан хугацаанд өргөжих боломж хязгаарлагдмал. Пёньян их хэмжээний зэвсэг, сум, галт хэрэгсэл Москвад тогтмол нийлүүлэх боломжгүй. Учир нь өөрийн батлан хамгаалах нөөцийг шавхах эрсдэлтэй. Түүнчлэн зэвсэг, хэрэгсэл үйлдвэрлэх эдийн засгийн нөхцөл хомс. Хоёр улсын хооронд бэлэн мөнгөний худалдаанаас илүүтэй бартерийн худалдаа давамгайлах магадлалтай тул бараа солилцоо, суурь эдийн засгийн чадавх сул улсад амьжиргаа залгуулах хэрэгцээг хангах нэг суваг л болно.

Умард Солонгостой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх Оросын чухал талбар бол хоёр улсын хоригт өртсөн салбар байж болно. Гэвч хориг арга хэмжээ авах санал өгсөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн өөрөө холбогдох тогтоолыг илт зөрчих асуудал аль алинд нь хязгаарлалт хийх шинэ шахалтын шалтгаан болох нь тодорхой. Оросыг түрэмгийлэгчийн хувьд НҮБ-аас хөөх, эсвэл хориг тавих эрхийг нь хасах хэрэгтэй гэх маргаан Өрнөдийнхний олон нийтээс цухалздаг⁶. Тийм ч учраас одоогийн байдлаар Оросын байр суурь “хориогүй зүйлийг зөвшөөрнө” гэсэн зарчмын дагуу хуучин хоригийг дагаж мөрдөх магадлалтай.

Объектив талаас нь үзвэл, Оросоос Умард Солонгост цэргийн дэвшилтэт технологи нийлүүлэх сонирхол байхгүй. Хоёр улсын харилцаа илүү ойр байсан ЗХУ-ын үед ч Москва үүнээс зайлсхийдэг байсан. Энэ нь дэвшилтэт технологийн дэмжлэг үзүүлснээр Пёньян Москвагийн хяналтаас гарах эрсдэлтэй холбоотой.

⁶ Justin Lane/EPA Stripping Russia's veto power on the Security Council is all but impossible. Perhaps we should expect less from the UN instead. <https://theconversation.com/stripping-russias-veto-power-on-the-security-council-is-all-but-impossible-perhaps-we-should-expect-less-from-the-un-instead-213985>. (retrieved: 2024.09.18)

Нөгөөтэйгүүр Умард Солонгос бага зардлаар Оросын зэвсгийг хуулбарлан үйлдвэрлэж, тус улсын зэвсгийн экспортыг бууруулах боломжтой. Түүгээр ч зогсохгүй эдгээр технологи, зэвсгийн систем Оростой дайсагнасан харилцаатай орнуудын гарт орох эрсдэлтэй. Харин Оросын зүгээс тагнуулын хиймэл дагуул зэрэг өөрийн аюулгүй байдалд заналхийлэх боломжгүй технологиудыг шилжүүлэх, хуваалцах талаар хамтран ажиллах магадлалтай. Иймд тив алгасагч баллистик пуужин, цөмийн зэвсгийн технологи зэрэг батлан хамгаалахын нэн чухал технологийг Оросын зүгээс Умард Солонгост дамжуулахгүй ч АНУ болон Өмнөд Солонгост шахалт үзүүлэх зорилгоор батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны идэвхжил болон зэвсгийн технологи нийлүүлэх боломжийн талаар байнга сануулах алхам байдлаар үлдэнэ. Өөрөөр хэлбэл, БНАСАУ-ын цөмийн зэвсэг нийлүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, эсвэл НҮБ-ын хориг арга хэмжээг илт дордуулах явдал Орост ашиггүй.

Батлан хамгаалах харилцан туслах гэрээ байгуулснаар Украинд явуулж буй цэргийн тусгай ажиллагаанд Умард Солонгосыг шууд татан оролцуулах боломж хомс. Өнгөрсөн онд нийлүүлсэн байж болзошгүй сум, хэрэгсэл шаардлага хангахгүй байгаа талаарх мэдээлэл гарсан. Түүнчлэн Умардын талаас их хэмжээний зэвсэг авах тохиолдолд Оросын иргэд Кремлийн батлан хамгаалах хүчин чадавхад эргэлзэх болно. Тиймээс Умард Солонгост хийсэн Оросын Ерөнхийлөгчийн айлчлалын үр нөлөө цэргийн тусгай ажиллагааны явцад шууд нөлөөлөхгүй, батлан хамгаалах хамтын ажиллагаа төдийлөн урагшлахгүй байх магадлал бий. Мөн Умард Солонгост АНУ тэргүүтэй Өрнөдийн улс орон цохилт өгөх тохиолдолд Орос шууд туслах эсэх эргэлзээтэй. Үүнийг Армени-Азарбайжаны мөргөлдөөнөөс харж болно. Армени ХАБГБ-ын гишүүн, гэтэл 2023 онд Азербайжан Арменийг довтолж, ялалт байгуулахад Орос хөндлөнгөөс оролцоогүй. Иймээс Умард Солонгостой шууд хүчээ нэгтгэх эргэлзээтэй. Гэхдээ Умард Солонгосын цэрэг Оросын Курск мужид Украины эсрэг байлдаж байгаагаас нөхцөл байдал өөрчлөгдөхийг үгүйсгэх аргагүй юм.

Аливаа дээд хэмжээний уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэхэд багагүй хугацаа шаардах төдийгүй хэдий чинээ өргөн цар хүрээтэй байна төдий чинээ бодит ажил хэрэг болгоход цаг хугацаа шаарддаг. Ямартай ч Умард Солонгост хийсэн В.Путины айлчлал, Москва Пёньянд дипломат дэмжлэг үзүүлж буйн илрэл, Өрнөдийнхөнд холбоотон улстай гэдгээ харуулах дипломат арга хэрэгсэл болсон. Орос-Өрнөдийн сөргөлдөөн даамжирвал ЗХА, Солонгосын хойгийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй. Тиймээс талууд “дараагийн түвшинд шилжих” баримт бичигт гарын үсэг зурахгүй байх магадлал өндөр.

Хоёр улсын хооронд сүүлийн хоёр жилийн хугацаанд хийсэн харилцан айлчлал бол АНУ болон Өрнөдийн орнуудад “мессеж” өгөх зорилгыг агуулсан. Харилцан туслах гэрээнд гарын үсэг зурсан явдал АНУ Украинд хэт их дэмжлэг үзүүлбэл Москва Пёньянд тусалж, ЗХА-д тогтворгүй байдал үүсгэж болзошгүй гэсэн дохиог Вашингтонд илгээж буй хэрэг. Түүнчлэн Өмнөд Солонгост мөн анхааруулга өгсөн дипломат алхам болсон. Өмнөд Солонгос их бууны том калибрын сумыг үйлдвэрлэдэг цөөхөн орны нэг. Тиймээс Сөүл Киевт ийм төрлийн

сум нийлүүлэх тохиолдолд Умард Солонгост технологи нийлүүлэх боломжтойг анхааруулсан дипломат ажиллагаа байсан үзнэ.

Дүгнэлт

Орос, Умард Солонгосын тал харилцан ашиг сонирхолд тулгуурлан харилцаагаа үргэлжлүүлэх хандлагатай байгаа ч хамтын ажиллагааны динамик нь геополитик, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтөөр тодорхойлогдоно.

Дээрх хоёр улсын хооронд цаашид өрнөж болзошгүй хоёр хувилбарыг дэвшүүлж авч үзлээ. Үүнээс хоёрдахь хувилбар буюу хоёр улсын харилцааны идэвхжил олон улсын тавцанд “мессеж” өгөх дипломат оролдлого байж болзошгүй хэмээн үзнэ. Нэг талаас Москва Пёньяны байр суурийг хүндэтгэх ч нөгөө талаас НҮБ-ын дүрэм, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх зарчмыг илэрхий зөрчиж дэлхийн дэг журмыг шууд устгах оролдлого хийхийг хүсэхгүй. Иймээс хоёр улсын харилцаа дунд болон удаан хугацаанд идэвхтэй өрнөх нь эргэлзээтэй.

Эдүгээ олон улсын амьдрал дэлхийн дэг журмын шинэ загвар руу аажмаар шилжиж байна. “Нэгдмэл Өрнөд” болон “Глобал Өмнөд” хоорондын сөргөлдөөн хурцдаж, НҮБ болон бусад холбогдох байгууллагууд “давхар стандарт”-ыг зөвтгөх тогтолцоо болж хувирч, шударга арбитрын үүргээ алдаж буй.

Улс орнууд дэлхийн дэг журмыг улс төр, дипломатын аргаар гэхээс илүүтэй дайн, цэргийн аргаар өөрчлөхийг эрмэлзэх болоод байна. Ийм нөхцөлд хүлээн зөвшөөрөгдсөн механизмууд ажиллахаа болих, дэлхийн шинэ дэг журам хараахан тодорхойлогдоогүй байгаа ч олон улсын аюулгүй байдлын уламжлалт бүтцийн олон элемент ач холбогдлоо алдах эрсдэлтэй байна. Энэ бүхэн олон улсын тавцанд улс хоорондын харилцаа хамтын ажиллагаанд хамтын эрх ашиг ихээхэн нөлөөлөхийг харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Россия и урегулирование ситуации на Корейском. https://mid.ru/ru/foreign_policy/vnesnepoliticeskoe-dos-e/krizisnoe-uregulirovanie-regional-nye-konflikty/uregulirovanie-situacii-na-korejskom-poluostrove/ (retrieved:2024.09.18)
2. Российско-корейские переговоры. <http://kremlin.ru/events/president/news/74330> (retrieved:2024.09.18)
3. Ким Чен Ын прибыл в Россию на роскошном бронепоезде. Что о нем известно. В составе есть поющие проводницы и большой выбор изысканных блюд. <https://www.rbc.ru/life/news/65005aa99a7947bfaf39eab5> (retrieved:2024.09.18)
4. US says North Korea delivered 1,000 containers of equipment and munitions to Russia for Ukraine war <https://apnews.com/article/north-korea-russia-us-munitions-ukraine-war-7091eaba254b680888a9b1ec8a68135f> (retrieved:2024.09.18)
5. Russians arrive in North Korea as first foreign tour group since COVID-19. <https://www.aljazeera.com/news/2024/2/9/russians-arrive-in-north-korea-as-first-foreign-tour-group-since-covid-19> (retrieved:2024.09.18)
6. Justin Lane/EPA Stripping Russia's veto power on the Security Council is all but impossible. Perhaps we should expect less from the UN instead. <https://theconversation.com/stripping-russias-veto-power-on-the-security-council-is-all-but-impossible-perhaps-we-should-expect-less-from-the-un-instead-213985>. (retrieved:2024.09.18)